

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН 2019 ОНЫ ТАЙЛАН МЭДЭЭ

Орхон аймгийн эрүүл мэндийн газарт 2019 онд иргэд, аж ахуйн нэгжээс нийт 246 өргөдөл гомдол, санал хүсэлт ирснээс бичгээр 24, цахимаар 212, биечлэн уулзаж 8 өргөдөл гомдол санал хүсэлт ирснийг хүлээн авч зохих хариу өгч ажиллаа.

2019 онд ирсэн нийт өргөдлийг агуулгаар авч үзвэл 69 буюу 45 хувь нь салбарын ажилтай холбоотой санал, хүсэлт, 143 буюу 25,6 хувь нь салбарын ажиллагсадын харилцаа хандлагатай холбогдолтой асуудлаар 27 буюу 10,5 хувь нь эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанартай холбоотой асуудал, 16 буюу 4,2 хувь нь ажилд орохыг хүссэн өргөдөл байна. Мөн энэ онд 34 гомдол ирсэн бөгөөд нийт өргөдлийн 10,8 хувийг эзэлж байна.

2019 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Эрүүл мэндийн харьяа байгууллагуудад иргэдийн санал хүсэлтийг хурдан шуурхай шийдвэрлэх үүднээс АЗДТГ-ын дэргэдэх 70353511-д ирсэн санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж биелэлтийг Даваа гариг бүр АЗДШуурхай хуралд биелэлтийг танилцуулдаг бөгөөд ЭМСБ-уудын шуурхай болон албан хаагчдын шуурхай хуралд ДТБХА-н мэдээллийг тогтмол хийдэг уламжлалтай болно.

2019 онд ЭМГ-ын ажилтнуудаас ЭМГ-ын удирдлагад гаргасан 30 өргөдлийг хууль журмын дагуу шийдвэрлэсэн болно.

**2019 ОНД ИРГЭДЭЭС ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ**

Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт хувь
		Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
Эрүүл мэндийн газар	246	246	-	-	-	100

**2019 ОНД ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ**

Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс				
		Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
Эрүүл мэндийн газар	246	24	212	2	8	-

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА /ХУВИАР/

Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал тоо, /нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
Эрүүл мэндийн газар	2019 онд ирсэн нийт өргөдлийг агуулгаар авч үзвэл 69 буюу 45 хувь нь салбарын ажилтай холбоотой санал, хүсэлт, 34 буюу 21 хувь нь салбарын албан хаагчдад талархсан асуудал, 16 буюу 4,2 хувь нь ажилд орохыг хүссэн өргөдөл байна. Мөн энэ онд 34 гомдол ирсэн бөгөөд нийт өргөдлийн 10.8 хувийг эзэлж байна.

..... оОо.....